

ВЕБ САЙТАД АЖИЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭХ ЗААВАР

Энэ удаагийн ажилчдын мэдээлэл шинэчлэх үед дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Ажилчдын **овог, нэр, регистрийн дугаарыг** үнэн, зөв оруулах.
2. Мөн ажилчдын **албан тушаалыг** зөв оруулах. Жишээ нь: Жолооч тэсэлгээчин, туслах тэсэлгээчин гэх мэт ойлгомжгүй албан тушаалыг оруулсан байна. Ийм учраас нягтлах шаардлагатай.
3. **Боловсролын гэрчилгээний** хуулбарыг тухайн ажилчдын үнэн, зөв, тод харагдах файлыг хавсаргах шаардлагатай.
4. Сургалтад ажилчдыг бүртгүүлэхдээ **холбогдох материалыг** үнэн зөв оруулна уу. Нэр болон холбогдох материал зөрсөн тохиолдолд **тухайн сургалтад суулгах боломжгүйг** анхаарна уу.

1. Цээж зураг оруулах заавар

УУХҮСайдын 2023.10.02 -ний өдрийн А/303 дугаар тушаалын "ҮНЭМЛЭХ ОЛГОХ, СУНГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ШААРДЛАГА" 1.5-р заалтын дагуу үнэмлэх **QR кодтой, пластик** болж дараах батлагдсан загварын дагуу хэвлэгдэх тул www.tsst.mn системд ИТАжилчдын шаардлага хангасан **3x4** хэмжээтэй нягтаршил сайтай цээж зураг **JPG** болон **PNG** файлаар 11 сарын 24-ний дотор оруулна уу.

Ажилчдын мэдээлэл дээр доорх зурагт харуулсан шиг Цээж зургийн файл оруулах гэсэн хэсэгт зургийг оруулна. Зургийн файлын хэмжээ хамгийн ихдээ 15МВ хүртэл байна.

Овог	<input type="text"/>
Нэр	<input type="text"/>
Регистрийн №	<input type="text"/>
Албан тушаал	<input type="text" value="Тэсэлгээчин"/>
Үнэмлэхний нөхцөл	<input type="text" value="Үнэмлэхний нөхцөл сонгох"/>
Үнэмлэхний дугаар	<input type="text"/>
Тэсэлгээчний үнэмлэхний зураг	<input type="text" value=".pdf устгах"/>
Үнэмлэхний хүчинтэй хугацаа	<input type="text" value="2024-08-29"/> <input type="button" value="Арилгах"/> (жил-сар-өдөр)
Утасны дугаар	<input type="text"/>
Боловсролын гэрчилгээний хуулбар	<input type="button" value="Файл оруулах"/>
Цээж зураг	<input type="button" value="Файл оруулах"/>

Шаардлага хангаагүй зураг оруулсан нөхцөлд тухайн ажилтны үнэмлэх хэвлэгдэхгүй болохыг анхаарна уу.

Шаардлага хангасан цээж зургийн жишээ:



Шаардлага хангахгүй зургууд жишээ:

Нүүрээ хаасан үстэй



Бараан дэвсгэртэй



Хуучин зураг



Цагаан дэвсгэр, цагаан цамцтай



Дотуур хувцастай




Сэлфи




Тамгатай



Далий авсан



Нүдний шилтэй



Хэт холоос авсан



Хар цагаан



Хэт ойроос авсан



Сканердсан






2. Системээс “Үнэмлэхийн төрөл” цэс хасагдаж “Үнэмлэхийн нөхцөл” цэс болон солигдсон. УУХУСайдын 2023.10.02 -ний өдрийн А/303 дугаар тушаалын “ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР” 1.5-р заалтын дагуу дараах 6 төрлийн сургалт зохион байгуулагдах бөгөөд үүний дагуу үнэмлэх олгогдох болно. Ийм учраас та бүгд үнэмлэхтэй ажилчдын үнэмлэхийн төрлийг зөв сонгож оруулна уу.

Манай байгууллагаас хэвлэх үед мөн давхар хянах болно.


Овог	<input type="text"/>
Нэр	<input type="text"/>
Регистрийн №	<input type="text"/>
Албан тушаал	Тэсэлгээчин
Үнэмлэхний нөхцөл	<div style="border: 2px solid red; padding: 5px;"> <p>Үнэмлэхний нөхцөл сонгох</p> <p>Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхтэй (Далд уурхайн нөхцөлд)</p> <p>Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхтэй</p> <p>Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхтэй</p> <p>Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажилд туслан гүйцэтгэх эрхтэй</p> <p>Үйлдвэрийн нөхцөлд ажиллах эрхтэй</p> <p>Тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй</p> <p>Тэсрэх материалтай шууд харьцахгүй зөвхөн тэсрэх материалтай өмнөх ажиллах эрхтэй</p> </div>
Үнэмлэхний дугаар	<input type="text"/>
Тэсэлгээчний үнэмлэхний зураг	<input type="text"/>
Үнэмлэхний хүчинтэй хугацаа	<input type="text"/>
Утасны дугаар	<input type="text"/>
Боловсролын гэрчилгээний хуулбар	<input type="button" value="Файл оруулах"/>
Цээж зураг	<input type="button" value="Файл оруулах"/>

Сургалт


1. “Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхийн үнэмлэх” олгох сургалтад хамрагдсанаар дараах үнэмлэх олгогдох болно.

 <p>Тэсэлгээний ажлыг удирдах эрхийн ҮНЭМЛЭХ</p>	<p>Үнэмлэх № 23/001</p>  <p>Овог: Дугар Нэр: Дондог Байгууллага: Монгол ХХК Нөхцөл: Уурхайн нөхцөл Нэмэлт эрх: Далд уурхайн нөхцөл Хүчинтэй хугацаа: 2025 01 31</p> 	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: Тэсэлгээний ажлын удирдагч Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхтэй. Сургалтанд хамрагдсан огноо: 2023 01 31</p> <p>Нэмэлт эрх: Далд уурхайн нөхцөл Нэмэлт эрх авсан огноо: 2023 02 28</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025 01 31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Мэргэжлийн комиссын дарга: Тамга _____ Гишүүд _____</p>
--	---	--


Системд дээрх үнэмлэхтэй ажилчдын нөхцөлийг “Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхтэй” гэж оруулж өгнө үү.




2. “Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхийн үнэмлэх” олгох сургалт.



Системд дээрх үнэмлэхтэй ажилчдын нөхцөлийг “Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхийн үнэмлэх” гэж оруулж өгнө үү.



3. “Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажилд туслан гүйцэтгэх эрхийн үнэмлэх” олгох сургалт.




Системд дээрх үнэмлэхтэй ажилчдын нөхцөлийг “Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажилд туслан гүйцэтгэх эрхтэй” гэж оруулж өгнө үү.




Шинээр үнэмлэхгүй ИТА бүртгүүлж байгаа тохиолдолд “Үнэмлэхийн нөхцөл” сонгон “Үнэмлэхийн дугаар” хэсгийг хоосон орхино.

4. “Үйлдвэрийн нөхцөлд ажиллах эрхийн үнэмлэх” олгох сургалт.




Системд дээрх үнэмлэхтэй ажилчдын нөхцөлийг “Үйлдвэрийн нөхцөлд ажиллах эрхтэй” гэж оруулж өгнө үү.




Шинээр үнэмлэхгүй ИТА бүртгүүлж байгаа тохиолдолд “Үнэмлэхийн нөхцөл” сонгон “Үнэмлэхийн дугаар” хэсгийг хоосон орхино.

5. “Тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгох” сургалт.




Системд дээрх үнэмлэхтэй ажилчдын нөхцөлийг “Тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй” гэж оруулж өгнө үү.



Шинээр үнэмлэхгүй ИТА бүртгүүлж байгаа тохиолдолд “Үнэмлэхийн нөхцөл” сонгон “Үнэмлэхийн дугаар” хэсгийг хоосон орхино.

6. “Тэсрэх материалтай шууд харьцахгүй зөвхөн тэсрэх материалтай харьцах орчинд ажиллах эрхийн үнэмлэх” олгох сургалт.



Системд дээрх үнэмлэхтэй ажилчдын нөхцөлийг “Тэсрэх материалтай шууд харьцахгүй зөвхөн тэсрэх материалтай харьцах орчинд ажиллах эрхтэй” гэж оруулж өгнө үү.



Анхаарах зүйлс:

1. Шинээр үнэмлэхгүй ИТА бүртгүүлж байгаа тохиолдолд “Үнэмлэхийн нөхцөл” сонгон “Үнэмлэхийн дугаар” хэсгийг хоосон орхино.
2. Эхний удаад болон сунгах үед пластик үнэмлэхийг үнэ, төлбөргүй хэвлэж өгөх ба хаягдаж гээгдүүлсэн, үнэмлэх шилжүүлсэн тохиолдолд төлбөр авна.
3. Одоо байгаа цаасан үнэмлэхийн нөхцөлд харгалзах үнэмлэхийн нөхцөлийг сонгоно уу. Одоогоор Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхтэй болон Далд уурхайн нөхцөлтэй ИТА байхгүй болно.
4. 2024 оноос эхлэн сургалтын төлбөрүүдэд өөрчлөлт орно.